



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 07 өдөр

Дугаар А/191

Алтай хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1.Дарив сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар тус сумын Хужирт, 3-р баг, 1-р багуудад мал угаалгын ванн барих ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

- Үнэлгээний хорооны дарга: Т.Сүхбаатар (Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
- С.Баярмаа (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)
- Г.Ууганбаатар (Хөндлөнгийн төлөөлөл) (тохиролцооноор)
- Б.Нямлхагва (Есөнбулаг сумын иргэн)
- Нарийн бичгийн дарга: О.Даваажаргал (Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)

2.Тендерийн баримт бичгийг боловсруулан гаргаж, худалдан авах ажиллагааг хугацаа алдалгүй чанартай зохион байгуулан, дүнг хуулийн хугацаанд танилцуулахыг Үнэлгээний хороо (Т.Сүхбаатар)-нд үүрэг болгосугай.

ОРЛОГЧ  Г.ЧИНБАТ